



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.04.11 № УАГ/ГАГ 02/59

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖЛИЙН САЙД С.ОЮУН
ТАНАА

**Гэрээний хэрэгжилтийг
хангуулах тухай**

“Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийх явцад БОАЖЯ, Цэвэр агаар сан, Дашваанжил ХХК-тай Автомашин хийгээр цэнэглэх 4ш суурин, 4ш зөөврийн нийт 8ш станц байгуулах 1890,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2012 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 80-120 хоногийн дотор барихаар гэрээ хийжээ.

Гэрээг БОАЖЯ-ны ТНБД Н.Батсуурь, ЦАС-ын гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх, Дашваанжил ХХК-ийн ерөнхий захирал Н.Баатаржав нар гарын үсэг зурж, Дашваанжил ХХК нь 1795,5 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч өнөөг хүртэл гэрээт ажил хэрэгжээгүй байна. (гэрээг 3 тал 2013 оны 8 дугаар сарын 15-ны өдөр хүртэл сунгасан)

Иймд Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.1-ийн 12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх,...” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Дашваанжил ХХК нь 1795,5 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт авч автомашин хийгээр цэнэглэх 4 ширхэг суурин, 4 ширхэг зөөврийн нийт 8 ширхэг станц байгуулах гэрээт ажил хугацаандаа хэрэгжээгүй, станцын барих эскиз зураг нь батлагдаагүй, газрын асуудал нь бүрэн шийдэгдээгүй зэрэг асуудлуудыг холбогдох байгуулагуудаар бүрэн шийдвэрлүүлж, гэрээт ажлыг 2013 оны 8 дугаар сарын 15-ны дотор хийж дуусгах арга хэмжээг авах
2. Хэрвээ Дашваанжил ХХК нь нэмэлт гэрээний хугацаанд хэрэгжүүлээгүй тохиолдолд гэрээг дахин сунгахгүй байж, гэрээний ерөнхий нөхцлийн 26.2-т заасан заалтын дагуу алданги тооцох
3. Тус компанитай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 3 талаас дүгнэж, ажлын үр дүнг 2013 оны 8 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор хариу мэдэгдэхийг Байгал орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн

070048

дарга Ж.Батболд, Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлсүх,
Дашваанжил ХХК-ийн захирал Н.Баатаржав нараас ШААРДАЖ байна

Бичсэн



Албан шаардлага



Танилцаж зөвшөөрсөн

БОНХЯ-ны ТНБ Дарга

Ж.Батболд

Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх
Захирал

Н.Хүрэлсүх

"Дашваанжил" ХХК-ийн ерөнхий
захирал

Н.Баатаржав

